



2007 оны 12 дүгээр сарын 3

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН,  
МАХН -ЫН БҮЛГИЙН ДАРГА Ц.НЯМДОРЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Л.ПҮРЭВДОРЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Н.БАТБЯАР ТАНАА

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах  
тухай хуулийн төсөлд санал өгөх тухай

Улсын Их Хурлаас Монгол Улсын татварын тогтолцоог либералчилах, олон улсын жишигт ойртуулах хүрээнд хийж буй эрх зүйн шинэчлэлтийг Монгол Улсын хувийн секторыг төлөөлж байгаа төрийн бус байгууллагууд талархан хүлээж авч байна.

Бид Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барьсан Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхааралтай судалсан. Хуулийн төсөлд санал болгож буй бүх өөрчлөлтүүдийг дэмжиж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ бидний зүгээс дараах нэмэлт өөрчлөлтийг санал болгон хэлэлцүүлэх хүсэлтэй байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын шимтгэл тооцох хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгах
2. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний сан болон түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоох

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлд зааснаар даатгуулагчийн шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дээд хэмжээг Засгийн Газар тогтоож байгаа ба хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн дүнгээр шимтгэл тооцох хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг тогтоодог ба энэ нь 2007 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн сарын 900,000 төгрөг болсон билээ.

Одоогийн байдлаар хөдөлмөрийн хөлсний энэхүү дээд хэмжээ нь зөвхөн ажилтан буюу даатгуулагчийн төлөх шимтгэлийг тооцоход хэрэглэж байгаа нь ажил олгогч болон ажилтан нар хуулийн өмнө тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг гажуудуулж байгаа юм.

Улсын Их Хурлаас санаачлан хэлэлцүүлж буй Нийгмийн даатгалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндсэн зорилго нь ажил олгогчийн төлөх шимтгэлийг бууруулах, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх явдал гэж бид ойлгож байгаа. Эдгээр зорилгыг улам бодитой, баттай хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулахаас гадна шимтгэл тооцох суурийн дээд хязгаарыг тогтоох хэрэгтэй гэж бид үзэж байна. Ингэж нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг бууруулснаар бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөг, зардал буурахын зэрэгцээ албан ёсны хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж түүнийг дагаад шимтгэл төлөгчдийн тоо өснө.

Нийгмийн даатгалын шимтгэл тооцох цалингийн дээд хэмжээг олон улсын практикт тухайлбал АНУ-д нийгмийн хамгааллын татварын хувь нь ажил олгогч ба ажилтан- даатгуулагчийн хувь тэнцүү 6.2% байдаг ба 2007 онд шимтгэл тооцох дээд хэмжээ нь жилийн 102,000 ам доллар байгаа бөгөөд шимтгэл тооцох дээд хэмжээг АНУ-ийн жилийн дундаж хөдөлмөрийн хөлсийг ойролцоогоор гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байдаг байна. Үүний адилаар эрүүл мэндийн даатгалыг ажил олгогч ба ажилтан-даатгуулагч тэнцүү 1.45%-иаар төлдөг ба Нийгмийн Хамгаалал болон Эрүүл Мэндийн даатгалын шимтгэл ажил олгогч ба ажилчдын нийт дүнгээр 15.3% байдаг байна.

Түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэл тооцох суурь цалинд дээд хязгаар тогтоох нь гадаадын дотоодын чадварлаг мэргэжилтэн, удирдах менежерүүдийг өндөр цалин урамшуулалтайгаар ажиллуулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай үндэсний үйлдвэрлэгч, ажил олгогчдийг шинээр бий болгох, хөгжүүлэхэд чухал хувь нэмэртэй байх болно. Харин нийгмийн даатгалын шимтгэл тооцох цалингийн дээд хязгаарыг тогтоохгүй байгаа нь Монголын аж ахуйн нэгжүүд чадварлаг менежерүүдийг тогтвор суурьшилтайгаар ажиллуулах, тэдний бодит цалин хөлсийг нэмэгдүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Үүний тулд нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг өөрчлөн найруулснаар (Хавсралт -1) ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний сангийн дээд хэмжээ хуульчлагдах юм.

Та бүхэн бидний саналыг судалж үзнэ гэдэгт итгэж байна. Энэ асуудлаар дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцоход бэлэн байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,



С.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛЫН ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ДАРГА



Л.НЯМСАМБУУ

МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

ПЕТЕР МОРРОУ

МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

## ХАВСРАЛТ 1

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх тухай 2007 оны 12 дүгээр сарын 3-ний албан бичгийн хавсралт

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулснаар (өөрчлөлтийг тод хараар бичив) ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх хөдөлмөрийн хөлсний сангийн дээд хэмжээ хуульчлагдах юм.

Нэмэлт, өөрчлөлтийг тод хараар тусгав.

32 дугаар зүйл. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын **бүрэлдэхүүн, дээд хэмжээ, дунджийг** тодорхойлох

**Ажил олгогчийн** болон даатгуулагчийн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын **бүрэлдэхүүн, дээд хэмжээ, дунджийг** тодорхойлох журмыг Засгийн Газар тогтооно.